

**2.10. Христос шашин дахь үгүйсгэсэн нэр томъёо бүхий
эзэн тэнгэрийн тухай сургаал**

Христос шашин дахь эзэн тэнгэрийн
тухай үзэл санаа

Түлхүүр үг: эртний Грек, иудаизм, Гэгээн Василий, Нисийн Григорий,
“Ареопагитик”, бурханы шашин.

Товч утга: Христос шашин анх үүссэн цагаас тавигдсан эзэн тэнгэрийг танин мэдэх арга замын тухай үзэл ойлголтууд энэ шашны нөлөөгөөр тодорхойлогдох өрнийн философийн түүхэнд оюун ухаан ба сүсэг бишрэлийн харьцааны тухай асуудал болж олон талаар яригдаж оюуны дасгалын нэгээхэн хэсэг болж иржээ.

Эзэн тэнгэрийн мөн чанарыг хэрхэн ухаарах тухай эрт үеэс тавигдсан энэ асуудлын хүрээнд үгүйсгэсэн нэр томъёо бүхий эзэн тэнгэрийн тухай сургаал боловсорчээ. Энэ сургаал Оросын үнэн алдрын шашны нэрт зүтгэлтэн С.Н. Булгаковын зохиолд тусгагдсаныг патристикийн томоохон төлөөлөгчдийн үзэл санааны жишээн дээр авч үзэж буддын шашин дүгээр илэрхийлэхэд хэцүү санаа буюу оюуны ямар нэг ухаарлыг хүнд хүргэхэд мөн “үгүйсгэсэн нэр томъёо” хэрэглэсэн байдагт анхаарал хандуулсан болно.

Олон шашин, олон үндэстний уулзвар болсон Ромын эзэнт гүрэнд үүссэн христос шашин эдгээр бүхний нөлөөн дор төлөвшсөн хэдий ч гол эх сурвалж нь өрнийн сэтгэлгээний тулгуур үндэс эртний Грекийн соёл ба анхан үеийн христос шашны анхдагч нийгэмлэгүүдийг бүрдүүлэгч еврейчүүдийн /10/ шашин иудаизм билээ.

Үлгэр домгийн үеэс орчлон ертөнц, ахуй гэж юу юм? Энэ бүх юмс хаанаас гарч ирсэн юм? Энэхүү орчлонд хүн ямар байр суурь эзэлдэг юм? Яаж амьдарвал зохилтой юм? Хүний хувь заяа ямар хүчин зүйлээс хамаардаг юм? Түүний хувь заяаг мэдэж, жолоодож байдаг хүчин байдаг болов уу? гэсэн асуудлууд хүн төрөлхтөний санаа бодлыг эзэмддэг байв. Дээрх асуудлын хариу болж орчлон ертөнцийг бүхэлд нь захирч мэдэх тэнгэрүүдийн талаархи ойлголт үүсч, овог аймгууд төвлөрч, хаант засаг төлөвших явцад бүхнийг чадагч эрхэт тэнгэрийн тухай монотеист сургаал бүрэлдэж байсны өрнийн ертөнц дэх тод томруун илрэл нь иудаизм байжээ.

Анхандаа овгийн дайчин тэнгэр байсан Яхве тэнгэр лүндэн буулгагч Моисейгээр дамжуулж өөрийн ард түмэндээ зарлигаа буулгаж, ёс суртахууныг нь хуульчилж өгсөн тухай Хуучин гэрээ өгүүлнэ.

Ертөнцийн үүтгэл болох санааны тухай үзэл эртний Грекийн философид мөн л чухал үүрэг гүйцэтгэж, ялангуяа шинэ платончууд болоод шинэ пифагорчууд эзэн тэнгэр, хүний ертөнц хоёрыг холбогч Логосын тухай ойлголтын үндсэн дээр Аврагч Есүс Христийн тухай сургаалаа боловсруулжээ. Аврагчийн тухай үзэл санаа эртний Ираны маздеизмд байснаас гадна Египет, Бага Ази дахь үхэж, дахин амилдаг үржлийн тэнгэрүүдийн тай тахилгууд мөн л нөлөөлсөн байх ажээ. / 8 /

Эдгээр үзэл санааны нийлэг болсон христос шашинд эзэн тэнгэр /Ертөнцийн эзэн/ нь өөрийн бүтээгдэхүүн /хүүхэд/ болох хүн төрөлхтөнд нийтээр дагаж мөрдөх ёс суртахууны зарчмыг нь лүндэнгүүд болон дохиогоор мэдүүлэх ба христос шашны Ариун судар Библийг эзэн тэнгэрийн бошиг лүндэн хэмээн үзэх ажээ.

Христос шашинд үл итгэх хүний үүднээс үзэхэд эдгээр бошиг лүндэн, дохио зангааг аливаа юмс үзэгдэл дэх шалтгаан нөхцлийн холбоог амьдрал практик, өөрийн үйл ажиллагаанаас олж мэдсэнээс хийсэн нэгэн дүгнэлт гэж үзэлтэй.

Ийнхүү христос шашинд эзэн тэнгэр гэдэг нь ахуйн бүх юмс үзэгдэл, хүнийг өөрийг нь бүтээж, хувь заяагийг нь мэдэж, юу хийж болох, юу хийж болохгүйг нь мэдүүлж өгөгч, хүний оршихуй, түүний утга учрыг тодорхойлогч хүчин болж хувирсныг мөнх бус амьдралын эцэст хүн оргүй хоосон үгүй болохыг хүсдэггүйтэй холбон үзэж болох юм. Эзэн тэнгэрийн тааллыг мэдэж, хүсэл зоригт нь нийцсэн үйл ажиллагаа явуулах нь мөнхийн сүнсээ аварч үхлийг ялан дийлэх гүн утга учир оруулах ажээ.

Католик, үнэн алдар, протестант зэрэг христос шашны олон урсгал чиглэл хоорондоо ялгаатай, зөрчилтэй байх хэдий ч ертөнцийг бүтээгч, бүхнийг чадагч эзэн тэнгэрийн тухай энэхүү ойлголттой холбоотой.

Эзэн тэнгэр нь “суурь өгөгдөхүүн”, “үнэмлэхүй судлагдахуун” учраас эзэн тэнгэр ба түүний үйл ажиллагааг мэдэрч буй хүний харилцаа холбооны илэрхийлэл хэмээн тайлбарлах шашны тахин шүтэх үйл ажиллагаа, ёс зүйн хэм хэмжээг эзэн тэнгэрт тэмүүлж буйн илэрхийлэл хэмээн үзнэ. Орчин үеийн, ялангуяа протестант шашны зарим чиглэлд эзэн тэнгэрээ нууцлаг хүчин мэтээр тайлбарлах явдал байдаг хэдий ч Библиэс уламжилсан ойлголтоор тэрхүү эзэн тэнгэрийг санаалаг бодгаль хэмээн төсөөлөх ажгуу.

Иудаизм болон христос шашинд бүхнийг чадагч, газар дэлхийг бүтээгч эзэн тэнгэр нь мөнх боловч өөрийн түүхтэй. Ертөнцийг бүтээхээс өмнө тэрхүү эзэн тэнгэр нь цорын ганц бодит байдал байв. Тэгснээ тэрээр өөрийн хүсэл зоригоор дэлхий ертөнц, ургамал, амьтдыг, эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээж зарлигаа ч тэдэнд буулгасан. Гэвч анхны хүмүүс болох Адам, Ева хоёр нүгэл хийж уналд орсноор хүн төрөлхтөний түүх эхэлнэ. Эзэн тэнгэр зан байдлыг нь ажиглан харж, лүндэн буулгагчдыг илгээж, хууль захиасаа хэлэн, шийтгэж, өөрийнхөө тухай мэдүүлнэ. Мессия буюу Аврагчийг илгээхийг амлана. Аврагч ирснээр түүний бүтээгдэхүүн хүнд эзэн тэнгэртэй эвлэрэх бололцоо гарч ирдэг.

Гэхдээ хэрэв иудейчүүд Мессия-г /аврагчийг/ ирнэ гэж үздэг бол /“эзэн тэнгэр” хүнийг уучлаагүй байгаа./ христос шашинтнуудын хувьд Мессия ирсэн, тэр нь Христос. /5, х. 226/ Тэрээр өөрийгөө зольж хүн төрөлхтөний ууган нүглийг төлсөн. Эзэн тэнгэр хүүгийнхээ биеэр өөрийгөө зольж хүний нүгэлт уналыг төлж авралын замыг нь зааж өгсөн. Нүгэлтэй хүн төрөлхтөний нүглийг гэм буруугүй ууган хүү Есүсийн биеэр өөрөө өөртөө төлж буй нигүүлсэнгүй хэмээгдэх христос шашны эзэн тэнгэрийн тухай сургаалийг үнэ төлбөргүй юм энэ ертөнцөд олддоггүй гэсэн эртний хүний аймшигтай ухааралтай холбон үзэж, үнэхээр нигүүлсэнгүй юм бол тэрхүү эзэн тэнгэр энэ бүхнийг хараад үхэх ёстой байсан хэмээн тайлбарлах философичид /9/ байх бөгөөд Европ дахь шашингүй үзлийн нэг уг сурвалж үүнд оршиж байсан гэж үзэж болох юм.

Иудаизмаас христос шашны ялгарах нэг онцлог Ариун Гурвалын тухай сургаал бөгөөд тэр нь эзэн тэнгэр бол оюун санаа гэдгийг илэрхийлэх ажээ. /12, х. 145/ Хэрэв Эцэг тэнгэр нь тэнгэр, газрыг, буй бүхнийг бүтээгч бол Хөвгүүн тэнгэр нь зуун зууны урагшид эцгээсээ төрсөн туйлын утга ба зарлиг, харин Ариун сүнс тэнгэр нь католик шашинд Эцэг тэнгэр, Хөвгүүн тэнгэрийн аль алинаас, үнэн алдрын шашинд гагцхүү Эцэг тэнгэрээс үүдэх амин сүнс, гэгээрэл мөн бөгөөд лүндэн буулгагчдаар дамжуулан хүмүүстэй харьцах ажээ. /5, х. 227/

Ариун Гурвалын тухай ойлголтыг Христос шашинтан хэн боловч итгэх ёстой тулгуур ойлголт болохынх нь хувьд сүмийн тухай үзэл номлолын хамтаар 325 оны Никейн чуулган дээр 12 гишүүн бүхий “Сүсэг бишрэлийн бэлгэдэл” хэмээх үзэл номлолоор баталгаажуулжээ. /3/ Үүнийг нь Христос шашинтны сүсэг бишрэлийн илэрхийлэл гэж үзэж болох юм.

Христос шашин анх үүссэн цагаас ертөнцийг үзэх үзэл, ёс суртахууны тулгуур ойлголт болсон тэрхүү эзэн тэнгэрийг оюун ухааны хүчээр нотолж болно гэсэн үзлийн хамтаар зөвхөн итгэл сүжиг, бошигт гэгээрлээр ухаарч болно гэсэн өөр нэг хандлага байсан нь сүсэг бишрэл ба оюун ухааны харьцааны асуудал болж Европын философийн түүхэнд тавигдаж иржээ. Итгэл сүжгээс өөрөөр эзэн тэнгэрийг таньж мэдэхийн аргагүй гэсэн санааг эртний Ром дахь патристикийн¹ анхан үе болох апологетикийн нэг төлөөлөгч Тертуллианы “Утгагүй учраас итгэнэм” /3/ хэмээх алдартай үг бүрэн илэрхийлнэ гэж үзэж болох юм.

Үгүйсгэсэн нэр томъёо бүхий эзэн
тэнгэрийн тухай сургаал

Эзэн тэнгэрийн мөн чанарыг хэрхэн ухаарах тухай эрт үеэс тавигдсан дээрх асуудлын хүрээнд үгүйсгэсэн нэр томъёо бүхий эзэн тэнгэрийн тухай сургаал боловсорчээ. /2/

Эзэн тэнгэрийг нэр томъёогоор илэрхийлэх аргагүй гэсэн санаа бүхий энэ сургаалийг Оросын үнэн алдрын шашны нэрт төлөөлөгч С. Булгаков “Үдшийн бус гэгээ” хэмээх зохиолдоо тусгасныг /2/ патристикийн “алтан үе” хэмээгдэх IV-V зуунд Бага Ази дахь Каппадоки нутгийн нэрээр каппадокийнхан хэмээн нэрлэгддэг Зүүн Ромын теологичдын жишээн дээр тоймлон авч үзье. Тэд гурван ипостась буюу эзэн тэнгэрийн гурван илрэлийн тухай санаагаа энэ сургаалдаа илэрхийлсэн. Үүнд нь юуны өмнө эзэн тэнгэрийн мөн чанарын тухай асуудал багтаж байсан ба христологийн асуудал бас хамрагдаж байв. Тэдний дотроос Василий 330-379 оны орчим амьдарч Бага Ази дахь Кесария хотын хамба лам / оросоор епископ/, “Зургаан өдөрт” /оросоор “Шестоднев”/ хэмээх дундад зууны үед өргөн дэлгэрсэн зохиолдоо шашны космологийн зарчмыг тодорхойлж, сүм хийдээс тэрс үзэлтнээр тодорсон Арийг эсэргүүцэж Гэгээн, Их Василий² хэмээн түүхэнд орсон ба Бага Ази дахь Нис хотын хамба лам Григорийн³ христос шашин дахь хүний сургаал болон ном судрыг тайлбарлах зарчмын тухай экзегетикийн онолын үндсийг боловсруулжээ. Өөр нэг

¹ Патристик - /Латин хэлний “эцэг” гэдэг үгнээс гаралтай/ - сүм хийдийн “эцэг” хэмээгдэх 2-8 зууны шашны томоохон төлөөлөгчдийн шашин философийн зохиолууд.

² “Творения иже во святых Отца нашего св. Василия Великого” изд. Моск. Дух. Акад., часть III стр. 28, 36 /против Евномия/ – С. Булгаков /2, стр. 103/

³ “Творения иже во святых Отца нашего св. Григория Нисского” том 6, Москва 1864, стр. 299. Опровержение Евномия, кн. XXII – С. Булгаков /2, стр. 104/

төлөөлөгч нь нэр нь тодорхойгүй Дионисий Ареопагитын нэрээр Y зууны 2 дугаар хагаст түгсэн арван захидал, дөрвөн зохиол бүхий "Ареопагитики" /1/ хэмээх шашин - философийн сурвалжуудын зохиогч ажээ.¹ /2/

Эзэн тэнгэрийг танин мэдэж, ойлголт ухагдахуунаар илэрхийлж болох, эсэх талаар Гэгээн Василийн үзэл санааг Христийн тэнгэрлэг мөн чанарыг үгүйсгэгч Арийн талыг /10/ баримтлагч байсан Евномийтэй ном хаялцсан тэмдэглэл харуулна. Гэхдээ уг асуудлыг хэлэлцэхдээ талууд ойлголт ухагдахуун гэдгийг нэр /оросоор "имена"/ гэсэн үгээр илэрхийлж байжээ.

Евномий эзэн тэнгэрийн мөн чанарыг "төрөөгүй" /нерождённость/ гэсэн ойлголтоор илэрхийлж болохын дээр энэ ойлголт Гурвалын гагцхүү нэгдэх илрэл /ипостась/ болох Эцэг тэнгэрт хамаарна гэж үзэж байв. Харин Гурвалын хоёрдох илрэл Хөвгүүн тэнгэр буюу Есүс Христ ийм шинжгүй гэж үзэж байснаараа тэрээр Христийн тэнгэрлэг мөн чанарыг үгүйсгэж тэрс үзэлтнээр тодорсон Арийн үзэлд хальтран орсон байх ажээ.

Евномийн үзэл санааг эсэргүүцэгч Василий:

Ямар ч нэр томъёо эзэн тэнгэрийг бүхэлд нь илэрхийлж чадахгүй. Эзэн тэнгэрийн талаархи ямарваа нэр томъёо аль нэг шинж түүнд байх эсэхийг тодотгохоос биш түүний мөн чанарыг нь үгээр илэрхийлж, оюун ухаанаар танин мэдэх боломжгүй гэж үзэн "түүний мөн чанарыг олно гэх ямар их омог вэ?...", хүний оюун ухаан эзэн тэнгэрийн үйл хэрэг, түүний бүтээгдэхүүнийг танин мэдэх замаар буянт санаанд нь ойртохоос авахаас биш мөн чанарыг нь ухаарч чадахгүй хэмээн зүтгэж байв.

Хариуд нь арийчууд /"аномей"/ "чи мэдэх юмандаа залбирч байна уу, мэдэхгүй юмандаа залбирч байна уу?" гэж асуухад Василий "Мөн чанарыг нь мэдэхгүй гэснээрээ би эзэн тэнгэрийг мэдэхгүй гээгүй. Түүний үйл хэрэг бидэнд мэдэгдэж байдаг хэдий ч үүгээр бид мөн чанарт нь ойртлоо гэсэн үг биш. Тэр бий гэдгийг нь л би мэднэ" хэмээжээ. Тэгвэл яаж аврагдах вэ? – Итгэл сүжгээр гэсэн хариултыг Василийн "итгэл сүжигтэй хүнд эзэн тэнгэр бий гэдгийг мэдэх нь хангалттай. Эзэн тэнгэр таньж мэдэгдэшгүй гэдгийг мэдэх нь мөн чанарыг нь танин мэдэж байгаа хэрэг" гэсэн үг илэрхийлнэ.

¹ De div.nom., I, I Migne, III, col. 583. – С. Булгаков / 2, стр. 106/. Мөн О.Л. Лутковскийн : "Мистическое богословие". Киев 1991 стр. 15 //, стр 588 А/ орчуулга байдаг байна. – С. Булгаков /2, стр. 381/

Нисийн Григорий найз /зарим мэдээгээр ах нь/ Василийнхаа нас барсны дараагаар үйл хэргийг нь залгуулж Евномийтэй ном хаялцаж адил байр суурийг баримталж байжээ. Тэрээр хүний оюун ухаан эзэн тэнгэр, анхдагч үүтгэл хүчнийг танин мэдэхийг зоривч ухаарч чадахгүйдээ түүний бүтээсэн үзэгдлийг шүтдэг. Эсвэл оршин буй орчны гоо сайхныг хүртэх замаар эзэн тэнгэрийг таньж мэдэхийг эрмэлздэг. Энэ эрмэлзэл нар, сар, од гариг зэрэг байгалийн үзэгдлийг шүтэхэд хүргэсэн хэмээн үзэж байжээ.

Нэр томъёо, бодол санаа, оюун ухааны бусад ямарваа хэрэглүүр эзэн тэнгэрийн мөн чанарыг бүхэлд нь багтаан илэрхийлж чадахгүй тухай үгүйсгэсэн нэр томъёо бүхий сургаалийн жинхэнэ эцэг нь нэр нь үл мэдэгдэх Ү зууны нэгэн зохиогч ажээ. Зохиолууд нь I зуунд амьдарч байсан Дионисий Ареопагитын¹ нэрээр дэлгэрсэн учраас “Дионисий Ареопагитынх гэгдэх зохиолууд” нэрээр түүхэнд оржээ. “Ареопагитики” хэмээх дээрх зохиолуудын агуулга эзэн тэнгэрийг хүний оюун ухаан танин мэдэх аргагүй, эзэн тэнгэр бол ахуй ба ахуй бусын нэгдэл, дэлхий ертөнц /универсум/ шатлан захирсан зохион байгуулалттай гэсэн санааг илэрхийлдэг байна.

“Тэнгэрлэг нэрсийн /нэр томъёоны/ тухай” гэдэг зохиолынх нь утга санаа хүний оюун ухаан эзэн тэнгэрийг таньж мэдэн, эерэг нэр томъёогоор мөн чанарыг нь багтаан илэрхийлж чадахгүй, гагцхүү үгүйсгэсэн нэр томъёо түүний талаар ойлголт өгч чадна гэдэгт оршиж байжээ. Харин эзэн тэнгэрийн талаархи эерэг хэллэг бүхий тодорхойлолтууд бошигт гэгээрлийн үр дүн бөгөөд Библи зэрэг эзэн тэнгэрийн зарлигт илэрхийллээ олсон байх ажээ.

Оршин буй юмс үзэгдлийн хэллэгээр бол эзэн тэнгэр нь Юу ч бус /Ничто/, учир нь тэр бол аливаа чанар, хөдөлгөөн, амьдрал, ургуулан бодохуй, төсөөлөл, нэр, үг, оюун ухаан, бясалгал, мөн чанар гэх мэтээс дээгүүр, нэг талаар нэр үгүй, нөгөө талаар бүх нэрийг багтаадаг тухай санааг дээрх зохиолууд мөн илэрхийлдэг байв.

“Эзэн тэнгэрийн тухай мистик сургаал” /“Мистическое богословие”/ зохиолдоо Дионисий Ареопагит хэмээгдэгч нь: “Бүх юмсын анхдагч шалтгаан нь бүхний дээр байх боловч мөн чанар үгүй бус, амьдрал үгүй бус, зарлиг үгүй бус, оюун ухаан үгүй

¹ Ареопаг /грек хэлээр “Аресын дов” гэсэн утгатай үг/ - нэр хүнд бүхий хүмүүсийн чуулган /эртний Афинд төрийн хяналт, шүүх цаазын үүрэг гүйцэтгэдэг засаг захиргааны байгууллага/. Гишүүд нь энэ үүргийг насан туршдаа гүйцэтгэнэ. Евангелийн домгийн дагуу Дионисий Ареопагит нь Афины Ареопагийн шүүгч байсан ба Христийн шавь апостол Павелын нөлөөгөөр христос шашинд орж, хожмоо Афин хотын анхны хамба лам болжээ.

бус. Нөгөө талаар биетэй бус, хэлбэртэй бус, дүр бүхий бус...", товчдоо тийм ч юм биш, ийм ч юм биш, "аугаа их бус" ажээ. /2, х. 108/ Юу ч бус-ын тухай ойлголт XIX-XX зууны Европын философид өргөн хэрэглэгдсээр ирсэнийг дурдууштай. /9,11/

"Үгүйсгэсэн нэр томъёоны" буддын шашин дахь уламжлалын жишээ гелүгва чиглэлийн үндэслэгч богд лам Зонхавын "Бодь мөрийн зэрэг" зохиолд олонтаа тааралддаг. Тус зохиолдоо тэрээр хуран эс үүдсэн номын би үгүйн хоосон чанарыг нотлох хэсэгтээ шүтэн барилдсаны учир шалтгааныг төв үзлийн үүднээс авч үзэхдээ Энэтхэгийн их сэтгэгч Нагаржунагийн "Үндэс билиг"-ээс эш татан "алин дор шүтэж алин болсон тэр нь хоромхон тэр бус, түүнээс бусад ч бус буюу. Тиймийн тул тасархай бус, мөнх бус хэмээсэн хийгээд ертөнцөөс нөхцсөн" /6, х. 190 б/, ямагт чанарыг /хоосон чанарыг/ илт оносон үеийн хэсэгтээ "тэр хоосон бус, хоосон бус ч бус, буй үгүй бус, үл төрөх бус, төрөх бус хэмээн тэр тэргүүтнийг ялж төгс номлов" /6, х. 209 б/ гэх зэргээр "үгүйсгэсэн нэр томъёо" хэрэглэсэн байдаг. Буддын философи дахь ийм нэр томъёоны олон жишээ манай судлаачдын бүтээлд мөн тусгалаа олсон нь бий. /7/ Ертөнцийг үзэх үзлийн хувьд өөр буддын болоод христос шашинд үгээр илэрхийлэхэд хэцүү санаа буюу оюуны ямар нэг ухаарлыг хүнд хүргэхэд "үгүйсгэсэн нэр томъёо" ийнхүү хэрэглэж ирсэн нь анхаарал татаж байна.

Summary. Ideas of Negative Theology in Christianity

Ideas of negative theology in Christianity represented in works of famous Russian Orthodox church philosopher S.N. Bulgakov are considered by some Eastern padres example. The author pays attention to the fact that negative categories are also used in Buddhist philosophy to express in words "Inexpressible" ideas or revelations.

Key words: Ancient Greece, Judaism, Blessed Vasillii, Gregory from Nis, Areopagitika, Buddhism

Ном зохиол

1. Атеистический словарь. М., 1984
- 2. Булгаков С.Н. "Свет невечерний". М., 1994
3. "История и теория атеизма". М., 1987
4. "История средних веков". Изд. Моск. унив., 2000

-
5. Каратини Роже "Введение в философию". М., 2003
 6. Лувсандагва (Зонхав). Гурван төрөлхтний анхааран авах бодь мөрийн зэрэг оршвой. Бээжин бар (Төвд хэл дээр). Цаасны хэмжээ 49.5х9.5. Барын хэмжээ 27х6. Мөрийн тоо 5. хуудасны тоо 223 (Эшлэлийг энэ номоор заав).
 7. Лувсандагва (Зонхав), Бага бодь мөрийн зэрэг оршив. Төвдийн Молом равжамба хийгээд Монголын гүүш Наганзуна Жүдва аягаа тахимлиг нарын монгол орчуулгаас хийсэн гар бичмэл (эшлэлүүдэд энэ орчуулгыг голлон тулгуурлав).
 8. Лувсанцэрэн Г. "Нагаржунагийн философийн үзэл". УБ. 1981
 9. Машкин Н.А. "История Древнего Рима". ОГИЗ, 1948
 10. Ницше Ф. "Антихрист" – сочинения в двух томах. Москва 1990, т.2
 11. Свенцицкая И.С. "Тайные писания первых христиан". М. 1980
 12. "Современная буржуазная философия". М. 1978
 13. Тойнби А. Дж. "Цивилизация перед судом истории". С.П., 1995